



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/50.

Ховд

Г Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "А", Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Хууль зүйн хороонд орсон байгууллагуудын чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж, Хүүхэд хамгааллын тухай хууль, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенци, "Хүүхдэд ээлтэй аймаг" стратегийн хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга /М.Тунамал-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга бөгөөд аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны дарга Н.Ганзоригт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/304 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00494
D/Zax-A/50-DP

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 23-ны өдрийн
A/50 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Хорооны дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Гишүүд: - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /зөвшилцсөнөөр/
- Аймгийн ерөнхий Прокурор, хууль цаазын шадар зөвлөх /зөвшилцсөнөөр/
- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга /зөвшилцсөнөөр/
- Цагдаагийн газрын дарга
- Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн зохицуулагч
- Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч
- Нарийн бичгийн дарга: - Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газрын Гэмт хэрэг, зөрчил, салбар эрх зүйн зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 23-ны өдрийн
A/50 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлж хамтран ажиллана.

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс:

- Хорооны дарга нь гишүүдийн ажил үүргийг хуваарилах
- Ажлын төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах,
- Хорооны хурлыг удирдах, тайлан мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах
- Шаардагдах төсөв санхүүжилтийг холбогдох байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх
- Хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлэх.

2. Аймгийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар:

- Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах шийдвэрийн хэрэгжилтийг хангах
- Хорооноос хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дунд хяналт тавих
- Хорооны үйл ажиллагаа болон иргэд байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлттэй холбоотой мэдээллийг хүлээн авч хорооны дарга, гишүүдэд танилцуулах

-Хорооны хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, холбогдох баримт бичгийн төслийг боловсруулах, албажуулах, сурталчилах, хорооны албан хэрэг хөтлөлт, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

-Хорооны гишүүд болон хамтран ажиллдаг байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах ажлыг зохион байгуулах

- Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өөрийн дэргэд гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхдэд тусламж үзүүлэх байртай байна.

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга:

-Хорооны үйл ажиллагааг орон нутгийн хүүхдийн зөвлөл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаатай холбох, хамтран ажиллах боломжоор хангах

-Хорооны үйлчилгээнд хамаарч буй хүүхдийн талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хороог төлөөлж асуудал дэвшүүлж, шийдвэрлүүлэх

-Хорооны хуралд оролцож санал гаргах, үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх, хорооны тайлан, мэдээ хүлээн авах, хорооны бодлого чиглэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөвт тусгах

4. Шүүхийн Тамгын газар:

-Хүүхдийн хэргийн дагнан шийдэх шүүгчийг томилон ажилуулахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд оролцсон хэргийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх.

-Хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх явцад хүүхдийн нэр төр, эрхийг хүндэтгэн үздэг харилцаа, ёс зүйг шүүхийн орчинд төлөвшүүлэх, хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн эрхийн талаар мэргэшүүлэх, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан хуульчийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

- Хүүхдийн асуудлаар гарсан шүүхийн шийдвэрийг хороонд сар тутам гаргах мэдээллэх.

5. Аймгийн прокурор:

-Прокурорын шатанд байгаа хүүхэд оролцсон, хохирсон гэмт хэрэг, хэргийн шийдвэрлэлтийн талаархи мэдээллээр хороог хангах.

-Хүүхдийн хэргийг дагнан шийдэх прокурорыг томилон ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд оролцсон зөрчил, хэргийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх.

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийн зөрчил гаргуулахгүй байхад анхаарч хяналт тавих, хүүхдийг саатуулах, баривчлах, хорих арга хэмжээг хамгийн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхийг эрмэлзэж ажиллах.

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүүхдийг эрүү шүүлт, хүнэлэг бус харицахаас хамгаалах.

6. Аймгийн Цагдаагийн газар:

-Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн талаарх мэдээллээр хороог хангах

- Хүүхэд оролцсон хэргийг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг хүүхэд ээлтэй орчинд явуулах, хэргийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

- Хүүхдийн эрхийн мэргэшлийн сургалтад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг тогтмол хамруулах, хүүхдийн эрхийг хүндэтгэх, ёс зүйтэй харилцааг албан хаагч наарт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах

-Хууль зөрчсөн хүүхдийг дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх талаар хороотой хамтран ажиллах

-Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэшсэн цагдаагийн ажилтныг томилон ажилуулах.

7. Боловсрол, соёл, урлагийн газар:

-Ерөнхий боловсролын сургуульд сурдаг хууль зөрчсөн, гэрч хохирогч хүүхдийн талаар мэдээллийг хороонд ирүүлэх

- Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн хэргийн болон хувийн нууцыг хадгалах, боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамрагдах, ялгаварлан гадуурхагдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх.

-Боловсролын нийгмийн ажилтныг хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхэдтэй ажиллах нөхцөл боломжоор хангах

-Сургуулиас гарсан, хасагдсан, завсардсан, бичиг үсэг мэдэхгүй хууль зөрчсөн, гэрч хохирогч хүүхдэд боловсрол олгох ажлыг зохион байгуулах

-Багшийн ажлыг дүгнэх, үнэлэх шалгуур үзүүлэлтэд хууль зөрчсөн хүүхдийн анги хамт олонд нь нэгтгэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх хүчин зүтгэлийг тусгаж, хэрэгжүүлэх

8. Эрүүл мэндийн газар:

-Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд шаардлагатай эмнэлэгийн тусlamж үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах

-Эмч эмнэлэгийн ажилтнууд хууль зөрчсөн, гэрч хохирогч хүүхдэд эмнэлэгийн тусlamж, үйлчилгээг хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, ёс зүйтэй, мэргэжлийн өндөр түвшинд хүргэх ажлыг зохион байгуулах

-Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийн эрүүл мэндийн байдлын талаар шаардлагатай мэдээллийг цагдаагийн байгууллагаад шуурхай хүргэх

9. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар:

-Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, ажилтай болгоход туслах

-Хууль зөрчсөн, гэрч, хохирогч өсвөр насын хүүхдийн эцэг, эх, ар гэрийн хүмүүсийг ажил, мэргэжилтэй болгоход дэмжлэг үзүүлэх

-Сургалт хүмүүжлийн байгууллагаас суллагдсан орон гэргүй өсвөр насын хүүхэд, түүний гэр бүлийг орон байраар хангах, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хамруулах

10. Монголын хуульчдийн холбооны гишүүн өмгөөлөгч:

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийг төлөөлж холбогдох байгууллагаад санал, хүсэлт, гомдол гаргах, хүүхдэд тулгарч буй асуудлаар хороог мэдээллээр хангах

-Хүүхдийн хэргийг шуурхай шийдвэрлэхийн тулд өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу авч хэрэгжүүлэх

-Шүүх ажиллагаанд оролцох, хороог мэдээллээр хангах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргах

11. Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн газар:

-Хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдэд шаардлагатай тохиолдолд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг мэргэжлийн түвшинд шуурхай хүргэх, холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх.